|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,670,594,040.01** | **143,270,783.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,655,638,974.00** | **143,270,783.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 336,438,974.00 | 138,270,783.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 47,677,300.00 | - |
| 210101 | Үндсэн цалин | 47,677,300.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,486,900.00 | 2,457,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 890,000.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,596,900.00 | 657,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,800,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 60,711,200.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 60,711,200.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 25,942,600.00 |
| 210604 | Урсгал засвар | | 25,942,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,968,000.00 | 992,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,968,000.00 | 992,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 212,595,574.00 | 108,878,283.01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 212,595,574.00 | 104,495,950.01 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 4,382,333.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,319,200,000.00 | 5,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,319,200,000.00 | 5,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,319,200,000.00 | 5,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **6,937,466.01** | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 6,937,466.01 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,017,600.00** | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 8,017,600.00 | - |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,017,600.00 | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,670,594,040.01 | 143,270,783.01 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,670,594,040.01 | 143,270,783.01 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 164,924,590.01 | 79,761,183.01 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,453,700.00 | 10,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,434,972,150.00 | 53,009,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 53,243,600.00 | - |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын зорилго нь: Үйлчлүүлэгчид, өрх, гэр бүлийн эрхийг дээдэлсэн, эрэлт хэрэгцээг хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлснээр эрүүл урт насалж, амьдралын чанар дээшилнэ.

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих, эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох, харьяалах хүн амын эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Аймгийн Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, эмнэлгийн тусламжийн тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны "Эрүүл мэндийн яамны салбарын НББ-ийн бодлогын баримт бичиг батлах тухай" 138 дугаар тушаалаар баталсан НББ-ын бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 180.9 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2й | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 5,100.0 | - | (5,100.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 1,054,606.3 | 870,120.3 | (184,486.1) |
| Үндсэн хөрөнгө | 706,650.3 | 715,328.2 | 8,678.0 |
| **Нийт хөрөнгө** | **1,766,356.6** | **1,585,448.5** | **(180,908.1)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,766,356.6 | 1,585,448.5 | (180,908.1) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,766,356.6** | **1,585,448.5** | **(180,908.1)** |

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 5.1 сая төгрөг буурсан нь ЭМЯ-наас 2021 оны эцсээр таван хүний нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг буцаан татсаныг авлагаар бүртгэж, он гараад санхүүжилтээр олгосонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 870.1 сая төгрөг болж 184.5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 69.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, ЭМЯ-наас 1260.9 сая төгрөгийн эм болон хамгаалах хэрэгсэл, эм реактив, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс товлолын дагуу дархлаажуулах, ковид-19 вакцинд 996.3 сая төгрөг бүгд 2327.1 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авсан байна.

Тайлант онд ЭМГ-т тусгай зориулалтын материалаас 1163.6 сая төгрөгийн вакцин, эм, эмнэлгийн хэрэгсэлийг зарцуулж, Эрүүл мэндийн даргын тушаалаар Нэгдсэн эмнэлэг болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудад 1336.1 сая төгрөгийн вакцин, эм, эмнэлгийн хэрэгсэлийг шилжүүлсэн. Газрын даргын 2022 оны А/80 тушаалаар 11.8 сая төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 715.3 сая төгрөг болж 8.7 сая төгрөгөөр өссөн нь 15.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, ЭМЯ-наас 34.1 сая, ХӨСҮТ-өөс 24.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 180.9 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 180.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 3166.1 сая, нийт зарлагыг 3166.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардал 30.8 сая, хангамж бараа материалын зардлыг 2.7 сая, норматив зардал 2.1 сая, эд хогшил урсгал зардал 7.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1.4 сая, бараа үйлчилгээний бусад зардал 6.4 сая төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 3123.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны анх батлагдсан төсөв 3098.5 сая төгрөг ба тодотгосон төсөв 3123.4 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 24.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 29.6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.1 сая, эд хогшил урсгал засварын зардлыг 3.9 сая, дотоод албан томилолтын зардлыг 3.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бараа материалын зардлыг 6.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 4.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.4 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Эрүүл мэндийн бодлого, удирдлага гэсэн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3123.4 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3123.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба гүйцэтгэл 100.0 хувьтай байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3064.4 сая төгрөг буюу 98.1 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3064.4 сая төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 27.7 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 7.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.1 сая, бусад урсгал шилжүүлэг 22.9 сая бүгд 59.0 сая төгрөг хэмнэгдэж хэмнэгдсэн төсвийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зарлагын 17.0 хувийг цалингийн зардал, 2.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 1.4 хувийг тогтмол зардал, 0.7 хувийг хангамж, бараа материалын зардал, 0.1 хувийг норматив зардал, 0.5 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 2.1 хувийг томилолт, зочны зардал, 1.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 0.7 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 75.4 хувийг бусад урсгал шилжүүлэг эзэлж байна

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтаар тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжид 52 хүнд 1196.5 сая төгрөг, 29.5 дахь заалтаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 244 хүнд 1112.3 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Хэмнэгдсэн зардлуудын заримыг тодруулахад дараах байдалтай байна. Тухайлбал:

- Тус байгууллагын 6 мэргэжилтэн тодорхой шалтгаанаар ажлаас халагдсан болон жирэмсэн, амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй байсан ажилчдын оронд хүн авч ажиллуулахгүйгээр хавсран ажиллуулсан нь цалингийн сан болон, НДШимтгэл 34.9 сая төгрөг хэмнэхэд нөлөөлсөн.

- Цэвэр, бохир ус, гэрэл цахилгааны хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашигласнаар төсвөөс 1.1 сая төгрөг хэмнэсэн.

- Тэтгэвэрт гарах нэмэлтээр захиалга өгсөн ажилтны материал тодорхой шалтгаанаар шаардлага хангаагүй учир 22.6 сая төгрөг хэмнэгдсэн.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 744,369.0 | 744,369.0 | - | 100% |
| 2 | Харуул, хамгаалалтын зардал | 32,032.0 | 32,032.0 | - | 100% |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 2,332,358.2 | 2,332,358.2 | - | 100% |
| 4 | Хөтөлбөр төслийн дотоод урсгал | 14,607.3 | 14,607.3 | - | 100% |
| | **Дүн** | **3,123,366.5** | **3,123,366.5** | **-** | **100%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас дэмжлэгт хяналт үнэлгээ хийх зардалд 7.0 сая, сургалт сурталчилгаа хийх зардалд 14.3 сая, эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламжийг сайжруулах сургалтанд 14.5 сая, аймгийн Засаг даргын тамгын газраас коронавируст цар тахалтай тэмцсэн үйл ажиллагааны урамшуулалд 0.5 сая, коронавируст халдварын омикрон хувилбар дотооддоо алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Цагааннуур автозамын боомтоос ачаа нэвтрүүлсэн импортлогч компанийн жолооч нараас халдвар илрүүлэх хурдавчилсан оношлуур болон ПГУ-ын шинжилгээг аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргэх шатахууны үнэд 10.0 сая, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоонoос сүрьеэгийн хавьталын үзлэгийн зардалд 6.7 сая, уул уурхайн үзлэгийн зардалд 8.2 сая, цогц үзлэгийн зардал 25.8 сая, ХӨСҮТөвөөс вакцин биобэлдмэлийн агуулахын засварын зардалд 25.9 сая, коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын нэмэлт тунг идэвхжүүлэх зардалд 1.0 сая, томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх бүсчилсэн сургалтын зардалд 10.9 сая, НЭМҮТөвөөс вакцинжуулах мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх зардалд 1.0 сая, Тэс петролиум компаниас хурдавчилсан оношлуурын үнэд 0.6 сая, Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалтын сургалтанд 1.7 сая, ТӨБЗГ-аас цахим тендерийн үйл ажиллагааны зардалд 0.6 сая, 2021 оны улсын төсвөөс авах авлага 5.1 сая нийт 143.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 64 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 10,896.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 217.9  сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний  хэрэгжилтийг шалгаж үзэхэд хэрэгжүүлээгүй дараах асуудлууд байна.  Үүнд:

- Хуулийн 15.2.6-д “Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”  гэж заасны дагуу үзэхэд Аймгийн Засаг даргын  2019 оны А/751 дугээр захирамжаар аймгийн ЭМГ-ын бүтэц орон тоог 43 орон тоогоор, ЭМЯ-наас 39 орон тоогоор тус тус баталсан, гүйцэтгэлээр 41 орон тоог төсөвтөө багтаан ажиллуулсан байна.

- Хуулийн 6.1-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэж заасан боловч ЭМГ-т "Ниссан патрол", Пургон, Хантер маркийн 3 суудлын  авто машин ашиглаж байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 онд нийт 3266.6 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулсан  байна.

Тайлант онд Засаг даргын дэргэдэх Санхүүгийн, хяналт дотоод аудитын алба, ЭМГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дотоод аудитор шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж аймгийн ЭМГ-ын үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 197.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад залруулга хийгдээгүй, 197.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжүүд өгөгдллөө.

### 5.1 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1.Байгууллагын бүтэц, орон тоотой холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Аймгийн Засаг даргын 2019 оны А/751 дүгээр захирамжаар аймгийн ЭМГ-ын бүтэц орон тоог 43 хүнээр, ЭМЯ-наас орон тооны хязгаарыг 39 хүнээр тус тус баталсан боловч гүйцэтгэлээр 41 орон тоогоор ажиллуулж ирсэн байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.3-д “бүх шатны Засаг дарга эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ

эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах" гэсэн заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай" журмыг мөрдөж орон тооны хязгаарыг хэтрүүлсэн зөрчил давтагдан гарч байгаа асуудалд дүгнэлт хийж , төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг үндэслэлтэй хийх, илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах.

***2.Үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 111 нэр төрлийн 197.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэсэн заалтыг мөрдөж, ээлэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох.

***3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

Аймгийн Эрүүл мэндийн газар нь "Ниссан патрол", Пургон, Хантер маркийн бүгд 3 суудлын авто машин ашиглаж байна.

*3.1 Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3, 6.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"-ын 204 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ анхны өртгөө | 1 | 197477.4 | | | | | | | 1 | | 1 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг зохих журмын дагуу шинэчлэн тогтоогоогүй | | | | | | | | | 197477.4 | | 197477.4 | |
| **Дүн** | **1** | **197477.4** | | | | | | **1** | **197477.4** | **1** | **197477.4** | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1.Аймгийн ЭМГ-ын бүтэц, орон тооны асуудлыг зохих журмын дагуу нэг мөр болгох | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| 2.Байгууллагын данс бүртгэлд байгаа суудлын автомашинуудын хууль журмын дагуу ашиглах | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Дүн | 2 | 0.0 | | | | | 2 | 0.0 |
| **Нийт дүн** | **2** | **0.0** | | | | | **2** | **0.0** |